



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 1/26

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "г", 29.1.6-ын "г", Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гарсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үйл ажиллагаа, ёс зүй, эрх бүхий байгууллагаас тогтоосон хууль дүрмийг сахин ажиллаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Эрдэнэсүрэн	-Аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн дарга
Нарийн бичгийн дарга:	Л.Оюунбаяр	-Аймгийн БСУГ-ын албаны дарга
Гишүүд:	Б.Мягмарсүрэн	-Аймгийн БСУГ-ын төсвийн мэргэжилтэн
	М.Баярхүү	-Аймгийн БСУГ-ын мэргэжилтэн
	Г.Эрдэнэбаатар	-Санхүүгийн хяналт аудитын албаны мэргэжилтэн

Хоёр. Хяналт шалгалтын дүнг 2017 оны 1 дүгээр сарын 30-ны дотор танилцуулж, цаашид хэрхэн шийдвэрлэх талаар санал, дүгнэлтээ ирүүлэхийг ажлын хэсэг /Ц.Эрдэнэсүрэн /-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200000000